
МЭДЭЭ · 2023 оны 4-р сарын 28

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО



Улсын ерөнхий прокурорын газрын prokuror.mn цахим хуудсаар дамжуулан прокурорын байгууллагын үйл ажиллагааны статистикийн мэдээлэлтэй танилцах боломжтой боллоо.

Тодруулбал, прокурор зөрчлийн болон эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийн хүрээнд хийсэн ажлын тоон мэдээллийг нарийвчлан гаргаж, prokuror.mn сайтын "Мэдээ, мэдээлэл" цэсний "Статистик" буланд байршууллаа. **ЭНД** дарж орно уу.

Цаашид дээрх мэдээлэл нь улирал, хагас жил, бүтэн жилээр гарах бөгөөд дараагийн улирал, хагас жил, жилийн эхний сар бүрт шинэчлэн нийтлэгдэж байх юм.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1849